

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ТАЗРЫН
ДАРГА. Б.НАРАНГЭРЭЛ

2024 оны... дүгээр сарын... өдөр

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ, СУДАЛГАА ХИЙХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны... дүгээр сарын...

Дугаар 24/27

Улаанбаатар хот

1.	Захиалагч байгууллага	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар
2.	Зорилго	Дүүргийн 34 хороодын иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний байгууллагын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, дүүргийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийн цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлоход оршино.
3.	Ажил гүйцэтгэх үндэслэл	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх журам", Дүүргийн Засаг даргын 2022 оны А/37 дугаар захирамж
4.	Хамрах хүрээ	-Баянгол дүүргийн 34 хороо -Баянгол дүүргийн хэлтэс, алба -Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар
5.	Үнэлгээ, судалгаа хийж үр дүнг тайлагнах нийт хугацаа	10 сар
6.	Хүний нөөцийн тоо, чадавхи	-Хэрэглэгчийн үнэлгээ, судалгаа боловсруулж төрийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагаанд 2-оос дээш удаа нэвтрүүлсэн туршлагатай байх; -Багийн ахлагч Статистик, судалгааны чиглэлээр 10-аас дээш жил ажилласан, магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх; -Гишүүд 5-аас дээш жил судалгааны байгууллагад ажилласан туршлагатай, эдийн засагч, социологич мэргэжилтэй, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, үүнтэй ижил төстэй судалгаа шинжилгээний ажил хийж байсан, тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мэргэжлийн программууд дээр ажиллах чадвартай байх;

7.	Гүйцэтгэх ажил	<p>Судалгааны сонгосон аргачлалын дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1. Хороо тус бүрээс 18-аас дээш насны 25-35 иргэнээс түүврийн аргаар судалгааг авна. 2. Судалгааны үр дүнгээр сэтгэл ханамжгүй байгаа асуудлуудад цаашид сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх үүднээс оновчтой шийдэл, санал, зөвлөмж боловсруулах; 3. Судалгааны үр дүнд тулгуурлан дүүргийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтийг сайжруулах санал зөвлөмж боловсруулах; 4. Эцсийн тайлан боловсруулах /санал, дүгнэлт, зөвлөмж/ 5. Судалгааны үр дүнг боловсруулж чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар цаашид авч хэрэгжүүлэх зөвлөмжийг улирал /нийт 4 удаагийн давтамжтай/ бүр хүргүүлж, дүгнүүлнэ.
8.	Хүлээгдэж буй үр дүн	<p>Захиалагчийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг, судалгаанд ашигласан материалуудын хамт хэвлэмэл болон цахим /*doc, *pdf*, *ppt, *xlsx өргөтгөлтэй/ хэлбэрээр тус бүр 3% бэлтгэж хүлээлгэж өгнө. Мөн хураангуй хэлбэрээр танилцуулга бэлтгэнэ.</p>

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.МӨНХБАЯР

БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *З. Анударь* З.АНУДАРЬ